



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/390

Булган сум

Төсөл хэрэгжүүлэгчдийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх байнгын ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсөл хэрэгжүүлэгчдийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх байнгын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: Байгаль орчны газрын дарга
Гишүүд: Байгаль орчны газрын Байгаль орчны Хяналтын улсын байцаагч
Сав газрын захиргааны Ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн
Сумын байгаль орчны Хяналтын улсын байцаагч
Сумын Байгаль хамгаалагч
Сумын иргэний төлөөлөл
Нарийн бичгийн дарга: Байгаль орчны газрын Газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн

2.Төсөл хэрэгжүүлэгчдийн тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг холбогдох журмын дагуу дүгнэж ажиллахыг ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

